ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЦЭЦЭГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/58/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Ховд хот<br>2021 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхтулга<br>Утас: 70432545<br>цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| *АДБОУС* | *Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт* |
| *АОУС* | *Аудитын Олон Улсын Стандарт* |
| *УСНББОУС* | *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* |
| *ТТЗ* | *Төсвийн төвлөрүүлэн захирагч* |
| *ТШЗ* | *Төсвийн шууд захирагч* |
| *ЗДТГ* | *Засаг даргын дамгын газар* |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

## Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ....................3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ....................5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН төгрөгөөр ....................5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр ....................5
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН төгрөгөөр ....................6
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ....................8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН төгрөгөөр ....................8
3.АУДИТЫН ТАЙЛАН ....................9
3.1. Ерөнхий зүйл ....................9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....................10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....................10
3.4. Материаллаг байдал ....................10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....................11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....................12
3.7. Шилэн дансны мэдээлэл ....................13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................13
3.9. Аудитын илрүүлэлт ....................13
Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно. ....................14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....................14
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ ....................14
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ ....................14

# 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

№ 4/164

танай ______ -ны № ______ -т

ЦЭЦЭГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ч.БУЯНДЭЛГЭР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэг сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэцэг сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанар зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Аудитын гол асуудал**

Ажилчдад олгосон хүнсний материалын үнийг бүрэн төвлөрүүлээгүй, авлагыг данс бүртгэлд тусгаагүй, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, И баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн, төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 14.4.2-д "[illegible] авлагыг заавал бүртгэнэ" гэж заасныг тус тус зөрчиж аудитын

"Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **36,421,088.40** | **61,427,960.45** |
| **33** | **АВЛАГА** | 9,356,018.00 | 17,853,940.05 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,958,782.00 | 15,653,940.05 |
| **335** | **Бусад авлага** | 3,397,236.00 | 2,200,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,102,236.00 | 1,500,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,295,000.00 | 700,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 27,065,070.40 | 43,574,020.40 |
| **351** | **Түүхий эд материал** | 42,000.00 | 452,700.00 |
| 35130 | Эм боох материал | 42,000.00 | 452,700.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 17,930,670.40 | 21,106,670.40 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,092,400.00 | 22,014,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,886,000.00 | 3,379,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 300,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,906,400.00 | 18,635,650.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **480,808,485.03** | **454,142,085.64** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 480,808,485.03 | 454,142,085.64 |
| **392** | **Биет хөрөнгө** | 473,028,485.03 | 446,362,085.64 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 465,563,830.00 | 465,563,830.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -25,034,370.84 | -48,093,841.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 42,226,218.00 | 47,014,218.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -31,056,211.00 | -35,303,587.75 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,856,058.00 | 43,856,058.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -24,367,337.39 | -28,514,889.19 |
| 39217 | Ном | 1,840,298.26 | 1,840,298.26 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,780,000.00 | 7,780,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,330,000.00 | 8,330,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **517,229,573.43** | **515,570,046.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **657,847.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 657,847.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 657,847.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 357,847.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 300,000.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 300,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **516,571,726.43** | **515,570,046.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 516,571,726.43 | 515,570,046.09 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 170,404,385.00 | 170,404,385.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 170,404,385.00 | 170,404,385.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -79,924,623.48 | -80,926,303.82 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -79,924,623.48 | -79,924,623.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -1,001,680.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 426,091,964.91 | 426,091,964.91 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **517,229,573.43** | **515,570,046.09** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **418,495,532.00** | **476,806,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,143,132.00** | **6,324,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,143,132.00 | 6,324,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,143,132.00 | 6,324,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12,143,132.00 | 6,324,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **406,352,400.00** | **470,482,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 374,498,500.00 | 440,510,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 374,498,500.00 | 440,510,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 737,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 737,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,853,900.00 | 29,234,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,853,900.00 | 29,234,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **431,294,143.60** | **477,808,180.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **431,294,143.60** | **477,808,180.34** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 431,294,143.60 | 472,453,901.34 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 276,739,573.00 | 332,210,175.95 |
| 210101 | Үндсэн цалин | 249,890,670.00 | 300,280,086.00 |
| 210104 | Урамшуулал | 26,848,903.00 | 31,930,089.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,768,706.00 | 41,755,169.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,768,706.00 | 41,755,169.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,540,450.00 | 29,209,671.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,656,350.00 | 2,803,371.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,544,100.00 | 26,011,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 340,000.00 | 395,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,303,300.00 | 1,607,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 434,400.00 | 562,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,186,000.00 | 908,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 118,100.00 | 118,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,564,800.00 | 19,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 49,723,250.00 | 29,279,950.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,000.00 | 1,399,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49,473,750.00 | 26,915,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 214,500.00 | 965,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 284,800.00 | 947,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 284,800.00 | 947,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 148,900.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 148,900.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 896,700.00 | 2,467,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 896,700.00 | 2,467,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,888,464.60 | 34,976,435.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 249,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,479,600.00 | 1,969,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,159,864.60 | 31,454,399.39 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 1,552,236.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 00.00 | 5,354,279.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 5,354,279.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 5,354,279.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-12,798,611.60** | **-1,001,680.34** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 4,740.05 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 4,740.05 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -4,740.05 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-12,803,351.65** | **-1,001,680.34** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **406,352,400.00** | **470,482,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **406,352,400.00** | **470,482,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 374,498,500.00 | 440,510,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 374,498,500.00 | 440,510,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 737,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 737,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 31,853,900.00 | 29,234,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,853,900.00 | 29,234,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **406,352,400.00** | **470,482,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **406,352,400.00** | **470,482,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **406,352,400.00** | **465,128,221.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 275,762,000.00 | 337,724,850.00 |
| 210101 | Үндсэн цалин | 191,338,075.00 | 220,493,669.86 |
| 210102 | Нэмэгдэл | 68,590,425.00 | 90,914,717.60 |
| 210104 | Урамшуулал | 15,833,500.00 | 26,316,462.54 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,470,100.00 | 46,284,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,439,800.00 | 32,110,387.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,757,600.00 | 3,543,917.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,206,000.00 | 2,835,273.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 551,500.00 | 707,486.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,515,200.00 | 7,087,634.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,654,700.00 | 29,214,671.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,631,600.00 | 2,803,371.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,623,100.00 | 26,011,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,351,700.00 | 2,250,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 143,700.00 | 143,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 746,000.00 | 908,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 118,100.00 | 118,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 82,100.00 | 82,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 261,800.00 | 998,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,601,400.00 | 45,372,150.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 77,000.00 | 2,418,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 57,795,400.00 | 41,813,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 729,000.00 | 1,140,350.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 199,200.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 199,200.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 148,900.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 148,900.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 200,200.00 | 200,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 200,200.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,964,200.00 | 4,081,650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 986,300.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,977,900.00 | 4,081,650.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **00.00** | **5,354,279.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 5,354,279.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 5,354,279.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **170,404,385.00** | **426,091,964.91** | **-79,924,623.48** | 516,571,726.43 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **170,404,385.00** | **426,091,964.91** | **-79,924,623.48** | 516,571,726.43 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **170,404,385.00** | **426,091,964.91** | **-79,924,623.48** | 516,571,726.43 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **170,404,385.00** | **426,091,964.91** | **-79,924,623.48** | 516,571,726.43 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **170,404,385.00** | **426,091,964.91** | **-79,924,623.48** | 516,571,726.43 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -1,001,680.34 | -1,001,680.34 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **170,404,385.00** | **426,091,964.91** | **-80,926,303.82** | 515,570,046.09 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 469,904,700.00 | 464,391,021.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 469,904,700.00 | 464,391,021.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 469,904,700.00 | 464,391,021.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 339,144,000.00 | 337,724,850.00 |
| 210101 | Үндсэн цалин | 213,464,300.00 | 220,493,669.86 |
| 210102 | Нэмэгдэл | 101,752,300.00 | 90,914,717.60 |
| 210104 | Урамшуулал | 23,927,400.00 | 26,316,462.54 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,601,800.00 | 46,284,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,007,000.00 | 32,110,387.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,398,700.00 | 3,543,917.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,718,900.00 | 2,835,273.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 679,900.00 | 707,486.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,797,300.00 | 7,087,634.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,234,600.00 | 29,214,671.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,823,300.00 | 2,803,371.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,011,300.00 | 26,011,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,519,700.00 | 1,513,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 143,700.00 | 143,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 914,000.00 | 908,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 118,100.00 | 118,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 82,100.00 | 82,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 261,800.00 | 261,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 48,535,600.00 | 45,372,150.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,238,000.00 | 2,418,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 44,968,600.00 | 41,813,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,329,000.00 | 1,140,350.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 159,400.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 159,400.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 148,900.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 148,900.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 343,600.00 | 200,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,600.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4217100.00 | 4081650.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,217,100.00 | 4,081,650.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 469,904,700.00 | 464,391,021.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 440,510,700.00 | 435,176,350.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 440,510,700.00 | 435,176,350.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 29,394,000.00 | 29,214,671.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 29,394,000.00 | 29,214,671.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 27 | 27 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 16 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10 | 10 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 175 | 175 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 175 | 175 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 175 | 175 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **27** | **27** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 17 | 17 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10 | 10 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **737,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **737,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 737,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 737,200.00 |
| 210604 | Урсгал засвар | | 737,200.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 737200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 737,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 737,200.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Цэцэг сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Ч.Буяндэлгэр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 18-наас 2021 оны 03 дугаар сарын 19–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

Ковид -19 цар тахлын үеэр хорио цээр тогтоосон байдал, нягтлан бодогч солигдож, эрүүл мэндийн шалтгаантай зэргээс хамаарч тайлант оны санхүүгийн тайлангийн хугацаа хоцорсон болно.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цэцэг сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд ”Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино‘’ гэж заасны дагуу *‘’Нутаг дэвсгэртээ сургуулийн өмнөх боловсролыг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх”’ зорилтыг дэвшүүлж ажиллажээ.*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цэцэг сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 431298.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4312.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 476806.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4768.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цэцэг сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1659.53 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, эздийн өмчийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| Авлага | 9,356.01 | 17,853.94 | 8,497.93 | 91% |
| Бараа материал | 27,065.08 | 43,574.02 | 16,508.94 | 61% |
| Үндсэн хөрөнгө | 480,808.48 | 454,142.08 | -26,666.40 | -6% |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **517,229.57** | **515,570.04** | **-1,659.53** | **0%** |
| **Богино хугацаат өр төлбөр** | **657.85** | **0.00** | -657.85 | **-100%** |
| Цэвэр хөрөнгө, өмч | 516,571.72 | 515,570.04 | -1,001.68 | 0% |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **517,229.57** | **515,570.04** | -1,659.53 | **0%** |

Авлага данс оны эцэст 17853.94 мянган төгрөг болж 8497.93 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд тайлант онд ажиллагсадтай холбоотой авлага 9695.16 мянган төгрөгөөр, байгууллагаас авах авлага 397.76 мянган төгрөгөөр нэмэгдэж хувь хүмүүсээс холбоотой авлага 1595.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43574.02 мянган төгрөг болж 16508.94 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 49119.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч БСУГ-аас 2825.0 мянган төгрөгийн бараа материал авсантай холбоотойгоор нийт 52594.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 34980.15 мянган төгрөгийн бараа материалыг бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж 455.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүнийг акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 480808.48 мянган төгрөг, оны эцэст 454142.08 мянган төгрөгөөр болж 26666.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 3499.0, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1289.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгджээ.

Тайлант оны элэгдлийн зардал 31454.4 мянган төгрөг байгаа нь үндсэн хөрөнгийн бууралтад нөлөөлжээ.

Өглөг дансны үлдэгдэлгүй болж 657.85 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хувь хүмүүстэй холбоотой 300.0 мянган төгрөг, ажиллагсадтай холбоотой 357.85 мянган төгрөгийн өглөгийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 515570.04 мянган төгрөг болж тайлант онд 1001.68 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Цэцэг сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 58310.97 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 58310.97 мянган төгрөгийн орлогоос 66012.2 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдэж 5819.13 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого, орон нутгийн төсвөөс 2619.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 46514.04 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 62457.06 мянган төгрөг буюу 20 хувиар, урсгал засварын зардал 662.7 мянган төгрөг буюу 232.6 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 5087.97 мянган төгрөгөөр буюу 17 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр 1570.7 мянган төгрөгөөр буюу 175.1 хувиар, урсгал шилжүүлэг 5354.3 мянган төгрөгөөр буюу 100 хувиар өсөж тогтмол зардал 2330.8 мянган төгрөг буюу 7.3 хувиар, хангамж бараа материалын зардал 5695.7 мянган төгрөг буюу 77.9 хувиар, нормативд зардал 20443.3 мянган төгрөгөөр буюу 41.1 хувиар томилолтын зардал 148.9 мянган төгрөгөөр буюу 100 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сургалтын үйл ажиллагаа түр хугацаагаар хаагдсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 469904.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 469904.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 12/02 тоот тогтоолоор Цэцэрлэгийн 2020 оны төсвийг 469904.7 мянган төгрөгөөр баталжээ.

### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 469904.7 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 29394.0 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 440510.7 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 440510.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 29234.6 мянган төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвөөс 159.4 мянган төгрөгийг дутуу авч нийт 469745.3 мянган төгрөгийн бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 464391.02 мянган төгрөгийг зарцуулж 53542.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 464391.02 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь нормативд зардлыг 3163.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 159.4 мянган төгрөгөөр томилолтын зардлыг 148.9 мянган төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг 135.5 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 5354.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолтын зардал, хог хаягдал орчны бохирдлын арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт /мян.төг/

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 126.15 |
| 81807 | Хүүхдийн хоол | 5011.7 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 196.5 |

| | | |
|---|---|---|
| 80109 | Тогтмол зардал | 19,9 |
| | ДҮН | 5354._2 |

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт дансаар 2020 онд сумын ОНХС-гаас 737.2 мянган төгрөгийн орлого орж цэцэрлэгийн байрны сантехникийн зардалд 737.2 мянган төгрөгийг зарцуулжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 91, хугацаа хоцроож мэдээлсэн 57 мэдээлэл, огт мэдээлээгүй 5 мэдээлэл байна. Дараа жилийн төсвийн төсөл, аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, батлагдсан төсвийг мэдээлээгүй байгааг аудитын явцад залруулан нөхөж мэдээллийг орууллаа.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад 7660.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 2 | 7660.2 | 0 | 0 | 2 | 7660.2 | 0 |
| **Нийт дүн** | **2** | **7660.2** | **0** | **0** | **2** | **7660.2** | **0** |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24027.65 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч илэрсэн алдаа зөрчилд 6173.75 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 17853.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

- Илрүүлэлт: 2020 онд ажилчдад тараан өгсөн хүнсний материалын үнийг багш, ажилчдаас буцаан суутган аваагүй, авлагаар бүртгээгүйтэй холбоотой 6173.75 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичигдлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. Төлбөрийн акт тогтоох

- Илрүүлэлт:Тайлант онд авлага 17853.9 мянган төгрөг болж өмнөх зөвлөмжөөр өгөгдсөн цалингийн урьдчилгааны авлагыг бууруулан ажиллах зөвлөмжийг

хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор албан шаардлага бичигдлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” заалтуудтай тус тус нийцээгүй байна

Шийдвэрлэсэн нь. Албан шаардлага тогтоох

**<u>Залруулсан алдаа</u>:** Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

**<u>Аудитын зөвлөмж:</u>** Аудитаар илэрсэн 1 алдаа зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1. Анхан шатны баримтын бүрдүүлэлтэй холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u> Тайлант онд гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.*

*1.2. <u>Эрсдэл:</u> Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх*

*1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах*

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| 2021 | ***Цэцэг сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | ХОА-2021/16/СТА-ТШЗ |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Цэцэг сумын цэцэрлэг | Мянган төгрөгөөр |
|---|---|---|

<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Алдаа, зөрчлийн товч утга</th><th rowspan="2">Мөнгөн дүн</th><th>Аудитын байгууллагаас гаргасан шийдэл</th><th colspan="2">Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны</th></tr>
<tr><th>Нэр</th><th>Албан тушаал</th><th>Овог нэр</th></tr>
<tr><td></td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td></tr>
<tr><td>1</td><td>Ажилчдад олгосон хүнсний үнийг суутган аваагүй, авлагаар бүртгээгүй</td><td>6173.75</td><td>Төлбөрийн акт</td><td rowspan="3">Эрхлэгч, Нягтлан бодогч</td><td rowspan="3">Ч.Буяндэлгэр<br>П.Бямбацогт</td></tr>
<tr><td>2</td><td>Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй авлагыг нэмэгдүүлсэн.</td><td>17853.9</td><td>Албан шаардлага</td></tr>
<tr><td>3</td><td>И баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн.</td><td>0</td><td>Зөвлөмж</td></tr>
<tr><td colspan="2">ДҮН</td><td>24027.65</td><td></td><td></td><td></td></tr>
</table>

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**